



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101
Утас: (976) 70442584

Цахим шуудан:procurement.bayankhongor@audit.gov.mn

2024.07.30 № 1/455

танай -ны № -т

Г Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд
заасан шаардлагад нийцсэн талаарх
дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4-т заасан Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох “Үндэсний эвсэл”-ийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох эвсэл нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох эвслийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Төрийн аудит. Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817-6:2020 Төрийн аудит. Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817-8:2020 Төрийн аудит. Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл,

Г БАЯНХОНГОР АЙМАГ, СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
2024 ОНЫ ЭЭЛЖИТ СОНГУУЛЬД
ОРОЛЦОХ ҮНДЭСНИЙ ЭВСЭЛД

5020555

2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох бусад байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

Дүгнэлт

“Үндэсний эвсэл”-ийн Баянхонгор аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

“Үндэсний эвсэл”-ийн мөрийн хөтөлбөр (..... хуудас)-ийг хавсаргав.

Хувийг: “Үндэсний эвсэл”-д

Хувийг: Баянхонгор аймгийн Сонгуулийн хороонд

Хавсралт хуудастай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

ХЯНАСАН:
АУДИТЫН МЕНЕЖЕР

БОЛОВСРУУЛСАН:
АХЛАХ АУДИТОР

АУДИТОР

АУДИТОР

Б.МӨНХБАТ

М.АЛТАНТУЯА

Б.ДОЛЖМАА

Н.БАТЧИМЭГ

Д.ЦЭДЭВЦЭВЭЭН

---ООО---




**БАЯНХОНГОР АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
2024 ОНЫ СОНГУУЛЬД “ҮНДЭСНИЙ ЭВСЭЛ”-ЭЭС ДЭВШҮҮЛЖ БУЙ
МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

Мөрийн хөтөлбөрийн үндсэн чиглэлүүд

1. ЭВ УХААНААР ЗАСАГЛАЯ
2. ЧАДДАГААР НЬ ХИЙЛГЭЕ
3. ХОТЛООРОО БАЯЖЬЯ
4. АЙМГАА НОГООРУУЛЯ

2024 оны 6 сар





0000001

“ҮНДЭСНИЙ ЭВСЭЛ”-ийн ДОТООД ИТГЭЛ:

Хөгжлөөрөө түүчээлэгч дэлхийн улс орнуудын амжилтын үндэс нь өрдөө ардчилал буюу арддаа хамтран засаглах эрхийг олгож, нийгэмдээ тэгш журamt дэглэмийг тогтоож, шилдгээ улс төрд илгээж, тэдгээрээс холч оновчтой бодлого гарч, бодлогынхоо хүрээнд хүүхэд залуучууддаа шилдэг боловсролыг, хувийн хэвшилдээ эрх чөлөөг олгосонд л байгаа юм.

Монгол хүний оюуны чадамж бусадтай харьцуулахад илүү юу гэхээс дутуугүй. Өнөөдөр цөөн хэдий ч монгол хүний чадамж гайхагдсан хэвээр. Тухайлбал, Монгол залуус хиймэл оюун ухаан зохион бүтээх, хүний биед хорт хавдар үүсэхээс өмнөх шинж тэмдгийг тогтоох туяа судлах зэрэг эрдэм шинжилгээний ажлыг нэр хүнд бүхий гадаадын их сургууль, шинжлэх ухааны байгууллагуудад хийж байна. Монголын залуус сансарт өөрсдийн зохион бүтээсэн хиймэл дагуулаа хөөргөж байна. Хувийн хэвшлийнхэн дэлхийн бизнесийн томчуудтай эн зэрэгцэн ширээний ард суух мэдлэг чадамжтай ч болж байна.

Монголчууд бидэнд хүчирхэг Монголоо эргэн цогцлоох боломж дүүрэн байна гэдэгт Үндэсний Эвсэл итгэдэг. Монголчууд бид эвсэж, хүчээ нэгтгэн асах, унтрахын зааг дээр байгаа цучил дээр хэт цахиур цохиж, хөгжлийн галыг бадрааж чадна гэдэгт Үндэсний Эвсэл итгэдэг.



БАЯНХОНГОР АЙМГИЙН МӨРИЙН ХӨТӨЛБӨР

1. ЭВ УХААНААР ЗАСАГЛАЯ

1.1. Цогц төлөвлөлт, цомхон удирдлагатай аймаг

- 1.1.1 Төрийн алба мэргэжлийн, нээлттэй, хариуцлагатай, цомхон байх өөрчлөлтийг аймгийн засаг захиргааны нэгжийн шинэчлэлтэй уялдуулан хийнэ.
- 1.1.2 Төрийн үйл ажиллагааг ил тод болгох замаар авлигатай тэмцэж, аймаг сумдын төрийн албаны мэдээллийн нээлттэй санг үүсгэн, иргэд төрийн үйл ажиллагаа, төсвийн хуваарилалт, шийдвэр гаргах үйл явцтай холбоотой мэдээллийг авах боломж бүрдүүлнэ.
- 1.1.3 Аймгийн төрийн албаны үйлчилгээг хүртээмжтэй, шуурхай, төрийн үйлчилгээг хялбар болгоно. Төрийн үйлчилгээний хүлээлтийн хугацааг эрс багасгаж, хэрэглэгчдэд ээлтэй болгоно.

1.2 Оролцоог хангах цахим засаглалтай аймаг

- 1.2.1 Бодлого боловсруулахад иргэдийн дуу хоолой-г тусгах зорилгоор олон нийтийн хэлэлцүүлгийг тогтмол зохион байгуулж цахим тогтолцоог ашиглан, иргэдийн оролцоо-г хангаж, төрийн шийдвэр гаргах үйл явцыг хүртээмжтэй болгоно.

2. ЧАРДАГААР НЬ ХИЙЛГЭЭ

2.1. Суурь шийдэлтэй аймаг

- 2.1.1. Дулаан хангамжийг сайжруулах шинэ технологи нэвтрүүлэгч хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтран ажиллах замаар сумдад бие даасан эх үүсвэрийг нэвтрүүлнэ.
- 2.1.2. Аймаг сумдын хэмжээнд одоо ашиглагдаж байгаа дулааны шугамыг нэмэгдүүлэх, хуучин шугамыг засварлаж сайжруулах ажлыг эрчимжүүлнэ.
- 2.1.3. Ус хангамжийг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд сумдын төвийн цэвэр усны сүлжээг нэмэгдүүлнэ.
- 2.1.4. Гудамж хорооллын бохир ус, ариутгах татуургын инженерийн шийдлийг төр хувийн хэвшлийн түншлэлийн замаар нэмэгдүүлэх төслийг хэрэгжүүлнэ.
- 2.1.5. Сумдын төвүүдэд, бие даасан инженерийн байгууламж бүхий орон сууцны барилгыг төсвийн хөрөнгөөр барьж байгуулан түрээсийн орон сууц хөтөлбөрийг нэмэгдүүлнэ.

2.2. Хүртээмжтэй аймаг

- 2.2.1. Боловсролын хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр сумдын сургууль, цэцэрлэг, дотуур байр, спорт заалны тоног төхөөрөмж, барилгын урсгал болон их засваруудыг шат дараатайгаар хийж сурган хүмүүжүүлэх нөхцөл байдлыг сайжруулж ажиллана.
- 2.2.2. Аймгийн боловсрол, соёлын салбарт гадаад улс орны хотуудтай санал солилцох, туршлага хуримтлуулах замаар гадаад хамтын ажиллагааг нэмэгдүүлнэ.

2.2.3. Аймгийн багш нарын боловсролыг чадавхжуулах замаар гадаад, дотоодын мэргэжил дээшлүүлэх сургалтад хамруулна.

2.2.4. Эрүүл мэндийн хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр орон нутгийн алслагдсан сумдын эмч ажиллагсдыг стандартад нийцсэн ажлын байртай болгох, нийгмийн асуудлыг сайжруулж ажиллана.


2.3. Тааламжтай орчинтой аймаг

2.3.1. Сум орон нутгийн хог хаягдлын нэгдсэн цэг нэг бүрийг дахин төлөвлөх, ариутгал халдвартгүйжүүлэх ажлыг үе шаттай зохион байгуулна.

2.3.2. Аймаг, сум, багийн бүх түвшинд гадна тохижилтын ажлыг үе шаттай хэрэгжүүлж ая тухтай амьдрахад таатай нөхцөлийг бүрдүүлнэ.

2.3.3. Сум орон нутгийн суурьшлын бүсүүдэд аюулгүй, амар тайван орчныг бүрдүүлэх камержуулах ажлыг нэмэгдүүлнэ.

2.3.4. Аймгийн хэмжээнд усны нөөцийг бохирдол хомсдолоос хамгаалах, зохистой ашиглах хүн амыг эрүүл ахуйн шаардлагад нийцсэн усаар хангах нөхцөлийг бүрдүүлнэ.



2.4. Иргэндээ зэлтэй аймаг

2.4.1 "Хүүхдэд зэлтэй аймаг" хөтөлбөрийн хүрээнд бүтээлч сэтгэлгээтэй, өөртөө итгэлтэй, байгаль, түүх, үндэсний хэл соёл уламжлалын чиглэлээр сургалт, арга хэмжээг зохион байгуулна.

2.4.2 Аймгийн залуучуудын боловсролд зээл тусlamжийн хүртээмжийг нэмэгдүүлж шаардлага хангасан бүх иргэнд алагчлалгүй олгох нөхцөлийг бүрдүүлнэ.

2.4.3 Ахмад настандаа идэвхтэй, эрүүл амьдрахад зориулсан "Ахмадад зэлтэй аймаг" хөтөлбөр санаачилж хэрэгжүүлнэ.

2.4.4 Аймаг орон нутгийн хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг идэвхжүүлэх, харилцаа хандлагыг хөгжүүлэх, нийгмийн үйлчилгээ үзүүлэх, сэргээн засах хөгжлийн төв байгуулна.

3. ХОТЛООРОО БАЯЖЬЯ

3.1. Бизнесийг дэмждэг аймаг

3.1.1 Дотоодын болон гадаадын аялагчдад зориулсан аяллын төрөлжүүлсэн маршрутыг боловсруулан орон нутгийн бизнес эрхлэгчдээ дэмжиж ажиллана.

3.1.2 Сум орон нутагт ахуйн үйлчилгээний төвүүдийг хувийн хэвшлийн оролцоотой барьж байгуулна.

3.2. Орлоготой иргэнтэй аймаг

3.2.1 Хөдөө аж ахуйн боловсруулах үйлдвэрүүдийг сум орон нутагт үе шаттай нэмэгдүүлнэ.

3.2.2 Бичил бизнес эрхлэгч нарын үйл ажиллагааг дэмжих, өргөжүүлэх зорилгоор дотоодын сургалтыг төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагаанд суурилан зохион байгуулна.

4.АЙМГАА НОГООРУУЛЪЯ

4.1 Ногоон орчинтой аймаг

- 4.1.1 Аймгийн ногоон ажил эрхлэлтийг дэмжиж ядуурлыг бууруулан ногоон амьдралын хэв маягийг төлөвшүүлэх сургалтуудыг зохион байгуулна.
- 4.1.2 Орон нутгийн нэрэмжит ногоон байгууламж бүхий бичил цэцэрлэгт хүрээлэн байгуулна.



Three handwritten signatures are arranged vertically on the right side of the page.

